



ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ,  
ГЕОДЕЗИ ЗУРАГ ЗҮЙН ГАЗАР



Schweizerische Eidgenossenschaft  
Confédération suisse  
Confederazione Svizzera  
Confederaziun svizra

Swiss Agency for Development  
and Cooperation SDC  
Швейцарын хөгжлийн агентлаг



МОНГОЛЫН  
БЭЛЧЭЭР АШИГЛАГЧДЫН  
НЭГДСЭН ХОЛБОО



УС ЦАГ УУР, ОРЧНЫ СУДАЛГАА  
МЭДЭЭЛЛИЙН ХҮРЭЭЛЭН



ШУА, ЕРӨНХИЙ БОЛОН СОРИЛЫН  
БИОЛОГИЙН ХҮРЭЭЛЭН

## МОНГОЛ ОРНЫ ЗОНХИЛОХ БЭЛЧЭЭРИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ, ӨӨРЧЛӨЛТИЙН ЗАГВАРУУД

Эмхэтгэсэн: Доктор, Дэнсамбуугийн Булгамаа  
Доктор, Индрээгийн Түвшинтогтох  
Магистр, Баттөрийн Анхцэцэг  
Магистр, Сайннэмэхийн Сүмжидмаа

Ерөнхий редактор: Доктор, Дэнсамбуугийн Булгамаа  
Доктор, Индрээгийн Түвшинтогтох

Редактор: Доктор, Улагваны Бекет (Өндөр уулын бүслүүр)  
Доктор, Чүлтэмжамцын Оюунцэцэг (Ойт хээрийн бүслүүр)  
Доктор, Намдагийн Лхагважав (Ойт хээрийн бүслүүр)  
Докторант, Лхагважавын Отгонтуяа (Ойт хээрийн бүслүүр)  
Доктор, Жадамбын Санжид (Цөлийн бүс)

Эх бэлтгэсэн: Магистр, Баттөрийн Анхцэцэг  
Магистр, Сайннэмэхийн Сүмжидмаа

Газрын зургийг бэлтгэсэн: Магистр, Уламбаярын Будбаатар

Дизайнер: Бат-Эрдэнэ Ариунболд

Хэвлэлийн хуудас: 9.75  
Цаасны хэмжээ: А4  
Хэвлэсэн тоо: 1000

ШИНЭЧИЛЖ САЙЖРУУЛСАН 4 ДЭХ ХЭВЛЭЛ

## ӨМНӨХ ҮГ

Монгол улсын нийгэм, эдийн засгийн хөгжлийг даган бэлчээрийн газрын ашиглалтын горим, ачаалал болон дэлхийн уур амьсгалын дулаарлын хавсарсан нөлөө улам бүр эрчимжиж буй өнөө үед бэлчээр ашиглалтыг бэлчээрийн ургамлын сэргэх чадавхи, даацад нь тохируулах замаар бэлчээрийн экосистемийг тогтвортой хадгалах, хамгаалах хариуцлагатай үүрэг бэлчээр зохион байгуулагчид, ашиглагчдын өмнө зүй ёсоор тавигдаж байна.

Ногоон Алт төслийн хүрээнд хийсэн бэлчээрийн экологийн чадавхийн урт хугацааны судалгаа, УЦУОСМХ, ГЗБГЗЗГ-ын мэргэжилтнүүд болон ШУА-ийн хүрээлэнгийн эрдэмтэд, зөвлөхүүдийн нөр их хөдөлмөрийн үр дүнд боловсруулан гаргасан “МОНГОЛ ОРНЫ БЭЛЧЭЭРИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ, ӨӨРЧЛӨЛТИЙН ЗАГВАРУУД”-ын шинэчилсэн хувилбарыг та бүхний гар дээр тавьж байна. Энэхүү хялбаршуулсан зурагт каталогийг эдүгээ бэлчээрийн төлөв байдлын мониторинг үнэлгээний мэдээллийг боловсруулж, түүний үр дүнгээр хэрэглэгчдэд үйлчлэх, бэлчээрийн газрын ашиглалтыг тухайн орон нутгийн экологи, нийгэм эдийн засгийн онцлогт тохируулан төлөвлөх, түүнийг хэрэгжүүлэх, бэлчээр ашиглалтын нөлөөг хянаж үнэлэх үндсэн арга хэрэгсэл болгон ашиглаж байна.

Энэхүү каталогит Монгол орны бэлчээрийн голлох төрлүүдээр унаган соргог болон өөрчлөгдсөн төлөв байдлын хувилбарууд, тэдгээрийн хоорондын шилжилт өөрчлөлтийг үе үеийн судлаачдын хээрийн судалгааны тоон мэдээлэл, эрдэмтдийн

мэдлэг туршлагад тулгуурлан тоон үзүүлэлтээр боловсруулан загварчилж, тухайн төлөв байдлыг тодорхойлох түлхүүр зүйл ургамлууд, боломжит бүтээмжийн талаарх мэдээллээс гадна ашиглалтын зохистой горим, хэлбэрийн технологийн зөвлөмжүүдийг хавсаргасан болно.

“МОНГОЛ ОРНЫ БЭЛЧЭЭРИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ, ӨӨРЧЛӨЛТИЙН ЗАГВАР”-ын шинэчилсэн хувилбараар бэлчээрийн экологийн чадавхийн бүлгүүдийн тархцыг засаг захиргааны нэгжээр тодруулсны зэрэгцээ сэргэх чадавхийн түвшнээс гадна доройтлын түвшний мэдээллийг нэмж орууллаа. Энэхүү каталогийн хэрэглээг улам өргөжүүлэх зорилгоор ургамлын бүрхэцийн шугаман цэгийн аргаар тодорхойлсон тоон мэдээллээс гадна уламжлалт буюу нүдэн баримжааны аргаар тодорхойлсон хувийг давхар оруулахын зэрэгцээ бэлчээрийн ургамлын төлөв байдал бүрээр зонхилгогч болон дэд зонхилгогч ургамлын мэдээллийг дэлгэрэнгүйгээр оруулсан.

Ус, цаг уурын болон газрын харилцааны улсын сүлжээн дээрх бэлчээрийн мониторингийн мэдээлэл боловсруулах, бэлчээрийн төлөв байдал, сэргэх чадавхийг үнэлэхэд, мөн сумын бэлчээр зохион байгуулалтыг төлөвлөх, хэрэгжүүлэх, ашиглалтын үр нөлөөг хянахад МОНГОЛ ОРНЫ БЭЛЧЭЭРИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ, ӨӨРЧЛӨЛТИЙН ЗАГВАР-ыг ашиглах бүрэн боломжтойг шинжлэх ухааны болон холбогдох байгууллагуудын зүгээс баталгаажуулж албажуулсан болно.

Газар Зохион Байгуулалт, Геодези, Зураг Зүйн Газар  
Ус, Цаг уур, Орчны Судалгаа Мэдээллийн Хүрээлэн  
ШУА-ийн Ерөнхий болон Сорилын Биологийн Хүрээлэн  
Монголын Бэлчээр Ашиглагчдын Нэгдсэн Холбоо  
Швейцарын Хөгжлийн Агентлагийн Ногоон Алт төсөл


# БЭЛЧЭЭРИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ ӨӨРЧЛӨЛТИЙН ЗАГВАРЫН ХЯЛБАРШУУЛСАН ХУВИЛБАРЫГ АШИГЛАХ ЗӨВЛӨМЖ

Бэлчээрийн экологийн чадавхийн бүлгийн нэр: Газрын гадаргын хэлбэр, хөрс, бэлчээрийг заана.

- Улаан сум: Төлөв байдал хоорондын шилжилт, доройтлыг илэрхийлнэ.
- ← Ногоон сум: Төлөв байдал хоорондын шилжилт, сэргэлтийг илэрхийлэнэ
- ← Тасархай ногоон сум: Төлөв байдал хоорондын шилжилт тодорхойгүй
- I-V Төлөв байдлын сэргэх чадавхийн түвшин

## 1. ЧУЛУУРХАГ ХӨРСТЭЙ УУЛЫН ЭНГЭР БОЛОН ЦАВ ТОЛГОДЫН ОРОЙ, ХАЖУУГИЙН ЧУЛУУСАГ АЛАГ ӨВС-БОТУУЛЬТ УУЛЫН ХЭЭРИЙН БЭЛЧЭЭР

Төлөв байдлын нэр



Тухайн төлөв байдалд зонхилох бүлгэмдлийн нэр

Төлөв байдлыг илэрхийлэгч ургамлууд

Тухайн төлөв байдлын дундаж ургац, боломжит даац


Бэлчээрийн төлөв байдлын шилжилт: Соргог төлөв байдлаас доройтсон төлөв байдал уруу чиглэлтэй

# БЭЛЧЭЭРИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ ӨӨРЧЛӨЛТИЙН ЗАГВАРЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ХУВИЛБАРЫГ АШИГЛАХ ЗӨВЛӨМЖ

Бэлчээрийн экологийн чадавхийн бүлгийн нэр: Газрын гадаргын хэлбэр, хөрс, бэлчээрийг заана.

Төлөв байдлын нэр


## 1. ЧУЛУУРХАГ ХӨРСТЭЙ УУЛЫН ЭНГЭР БОЛОН ЦАВ ТОЛГОДЫН ОРОЙ, ХАЖУУГИЙН ЧУЛУУСАГ АЛАГ ӨВС-БОТУУЛЬТ УУЛЫН ХЭЭРИЙН БЭЛЧЭЭР



Бэлчээрийн төлөв байдлын шилжилт: Соргог төлөв байдлаас доройтсон төлөв байдал руу чиглэнэ.

# БЭЛЧЭЭРИЙН МОНИТОРИНГ, ҮНЭЛГЭЭНИЙ ТООН МЭДЭЭГ БОЛОВСРУУЛАХ ҮНДСЭН АРГА ХЭРЭГСЭЛ БОЛОХ НЬ

Ус, цаг уурын улсын сүлжээн дээр:




Species	Scientific	Common	Year	Foliar Cover %	Root Cover %
1	Alnus incana (L.) Mill.	Хангалуу	2010	20.0	0.0
2	Populus euphratica	Хангалуу	2010	10.0	0.0
3	Salix caprea	Хангалуу	2010	5.0	0.0
4	Ulmus glaberrimus	Хангалуу	2010	3.0	0.0
5	Alnus glutinosa	Хангалуу	2010	2.0	0.0
6	Salix elaeagnifolia	Хангалуу	2010	1.0	0.0
7	Ulmus glaberrimus	Хангалуу	2010	0.5	0.0
8	Alnus glutinosa	Хангалуу	2010	0.5	0.0
9	Salix caprea	Хангалуу	2010	0.5	0.0
10	Ulmus glaberrimus	Хангалуу	2010	0.5	0.0
11	Alnus glutinosa	Хангалуу	2010	0.5	0.0
12	Salix caprea	Хангалуу	2010	0.5	0.0
13	Ulmus glaberrimus	Хангалуу	2010	0.5	0.0
14	Alnus glutinosa	Хангалуу	2010	0.5	0.0
15	Salix caprea	Хангалуу	2010	0.5	0.0
16	Ulmus glaberrimus	Хангалуу	2010	0.5	0.0
17	Alnus glutinosa	Хангалуу	2010	0.5	0.0
18	Salix caprea	Хангалуу	2010	0.5	0.0
19	Ulmus glaberrimus	Хангалуу	2010	0.5	0.0
20	Alnus glutinosa	Хангалуу	2010	0.5	0.0

**БЭЛЧЭЭРИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН МЭДЭЭЛЭЛ ҮЙЛЧИЛГЭЭ**

**БЭЛЧЭЭРИЙН СЭРГЭХ ЧАДАВХИД СУУРИЛСАН ТӨЛӨВЛӨЛТ АШИГЛАЛТ**



Бэлчээрийн газрын зохион байгуулалтанд:



# ХОЛБОГДОХ ТУШААЛ ШИЙДВЭРҮҮД

  
**ГАЗРЫН ХАРИЦАА, ГЕОДЕЗИ,  
ЗУРАГ ЗҮЙН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ**  
 2015 оны 05 сарын 22 өдөр  
 Дугаар А/104  
 Улаанбаатар хот

**Сумын газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөө боловсруулах аргачлалд нэмэлт оруулах тухай**

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 зүйлийн 8.4 дэх хэсэг, Газрын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2.8, 23.2.12, тус Газрын даргын дэргэдэх зөвлөлийн 2015 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

ГХГЗЗГ-ын даргын 2010 оны 497 тоот тушаалаар батлагдсан "Сумын газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөө боловсруулах аргачлал"-д дараах нэмэлтийг оруулсугай. Үүнд:

а. Хавсралт долоо, "Бэлчээрийн төлөв байдал, өөрчлөлтийн загварыг ашиглах зөвлөмж"

ДАРГА  А.ХҮРЭЛШАГАЙ

0000437

  
**ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ  
ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ**  
 2015 оны 11 сарын 30 өдөр  
 Дугаар А/163  
 Улаанбаатар хот

**Загвар, аргачлал ашиглах тухай**

Монгол улсын "Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай" хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх заалт, "Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай" хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, "Төсвийн тухай" хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.4 дэх хэсэг, Газрын дэргэдэх арга зүйн зөвлөлийн 2015 оны 5 дугаар хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Экологийн чадавхи дээр суурилсан төлөв байдлын өөрчлөлтийн загвар, аргачлал"-ыг 2016 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн Хөдөө аж ахуйн цаг уурын улсын сүлжээнд нэвтрүүлж, ашигласугай.

2. Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний улсын сүлжээнд хийж байгаа бэлчээрийн төлөв байдлын мониторингийн мэдээллийн санг баяжуулж, "Экологийн чадавхи дээр суурилсан төлөв байдлын өөрчлөлтийн загвар" аргачлалаар мэдээнд боловсруулалт хийж, Монгол орны бэлчээрийн төлөв байдлын тайлан мэдээ гаргаж байхыг Ус цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэн, Аймаг, нийслэлийн Ус цаг уур, орчны шинжилгээний албадад даалгасугай.

3. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг тус газрын дэд дарга Б.Баттулга, Ус цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн захирал С.Хөдөлмөр, Аймаг, нийслэлийн Ус цаг уур, орчны шинжилгээний албадын дарга нарт үүрэг болгосугай.

ДАРГА  Д.ЦОГТ-ОЧИР

0162

**ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ  
ЕРӨНХИЙ БОЛОН СОРИЛЫН  
БИОЛОГИЙН ХҮРЭЭЛЭНГИЙН  
ЭРДМИЙН ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ**  
 2014 оны 05 сарын 31 өдөр  
 Дугаар 03  
 Улаанбаатар хот

**"Монгол орны бэлчээрийн төлөв байдал, өөрчлөлтийн загварууд"-ыг дэмжих тухай**

Ус, цаг уур болон газрын харцгааны систем дэх бэлчээрийн мониторингийн улсын сүлжээг бэхжүүлэх зорилгоор "Монголын бэлчээр ашиглагчдын нэгдсэн холбоо"-оос Ногоон алт-Малын эрүүл мэнд төслийн дэмжлэгээр УЦУОШГ, ГЗБЗЭГ, ШУА-ийн Ерөнхий болон сорилын биологийн хүрээлэнгтэй хамтран боловруулсан "МОНГОЛ ОРНЫ БЭЛЧЭЭРИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ, ӨӨРЧЛӨЛТИЙН ЗАГВАРУУД" гарын авлагын зохиогчийн эхийг эрдэмийн зөвлөлийн хурлаар хэлэлцээд ТОГТООХ НЬ:

1. "Монгол орны бэлчээрийн төлөв байдал, өөрчлөлтийн загварууд" гарын авлагат манай орны бэлчээрт зонхилох 22 бэлчээрийн хэвшинж, тэдгээрийн бэлчээрийн ашиглалтын нөлөөгөөр доройтох, сэргэх үе шатуудыг загварчсана, үе шат бүрийн ургамал бүлэгэмэл, зонхилгогч ургамал, шалгуур үзүүлэлт, зуны дэх ургам, бэлчээрийн боломжит даавж тооцон оруулсан байна. Энэхүү загварыг гаргахдаа Ногоон Алт төслийн хүрээнд сүүлийн 10 жилийн хугацаанд хийсэн бэлчээрийн экологийн чадавхийн судалгаа болон бусад эрдэмтэн судлаачдын хийсэн ургамалжлын судалгааны үр дүнд суурилсан боловсруулсан нь онолын судалгааны үр дүнг хялбаршуулан практикт ашиглах боломжтой, шинэстэх ухааны үндэслэлтэй бүтээл болсон хэмээн үзэсүгэй.
2. Уг гарын авлагат орсон зүйл ургамалын зургийн чанарыг сайжруулан, хэвлэл нийтлүүлж, бэлчээрийн ургамалын сэрэх чадавхи, даваал нь тохируулан бэлчээрийг тогтвортой ашиглах зорилгоор бэлчээр зохион байгуулагчид болон бэлчээр ашиглагчдын хэрэгтэнд шилжүүлэх боломжтой гэж үзэсүгэй.

ДАРГА  Я.АДЪЯА  
 НАРИЙН БИЧГИЙН ДАРГА  Э.АРИУНБОЛД

D:\Banka-A4\Togool

## ОЙТ ХЭЭРИЙН БУСЛУҮР

### УУЛ БОЛОН ЦАВ ТОЛГОДЫН ОРОЙ, ХАЖУУ

1. Чулуурхаг хөрстэй уулын  
энгэр болон цав толгодын орой,  
хажуугийн Чулуусаг алаг өвс-  
ботуульт уулын хээрийн бэлчээр

### УУЛЫН ХАЖУУ, ХӨНДИЙ

2. Шавранцар хөрстэй уулын хажуу,  
бэлийн Алаг өвс-жижиг дэгнүүлт  
үетэнт уулын хээрийн бэлчээр

3. Шавранцар хөрстэй уулын  
хажуугийн Сөөгөн боролзгоно  
бүхий Улалж-үетэн-баялаг алаг өвст  
нугын хээрийн бэлчээр

4. Шавранцар хөрстэй уулын  
бэл, хөндийн Алаг өвс-байгалын  
хялганат нугын хээрийн бэлчээр

### ГОЛЫН ТАТАМ


5. Алаг өвс-үетэнт татмын нугын  
бэлчээр

### 1. ЧУЛУУРХАГ ХӨРСТЭЙ УУЛЫН ЭНГЭР БОЛОН ЦАВ ТОЛГОДЫН ОРОЙ, ХАЖУУГИЙН ЧУЛУУСАГ АЛАГ ӨВС-БОТУУЛЬТ УУЛЫН ХЭЭРИЙН БЭЛЧЭЭ

Төлөв байдал

Зонхилогч ургамал

Үндсэн шалгуур



Зонхилогч: Ленийн ботууль, Сунагар биелэг, Том цэцэгт даагансүүл  
 Дэд зонхилогч: Хялгасан дэвхэргийн цагаан, Шивүүрт жав, Хадны бөгтөргөнө, Турчаниновын яргуй

Зонхилогч: Ленийн ботууль, Дэрвээн хазаар өвс, Том цэцэгт даагансүүл  
 Дэд зонхилогч: Агь, Хависгана навчит бэриш, Хялгасан дэвхэргийн цагаан, Хадны бөгтөргөнө, Буурал гандбадраа

Зонхилогч: Агь  
 Дэд зонхилогч: Дэрвээн хазаар өвс, Хялгасан дэвхэргийн цагаан, Шүдлэг сонгино, Ишгүй гичгэнэ

Зонхилогч: Агь  
 Дэд зонхилогч: Ишгүй гичгэнэ, Арзгар согсоолж зэрэг доройтлын таниур ургамлууд

Ленийн ботууль 15-25%  
 Жигж дэгнүүлт үетэн 10-15%

Жигж дэгнүүлт үетэн >15%  
 Агь <15%

Агь >15%  
 Жигж дэгнүүлт үетэн <15%

Агь >20%

Ленийн ботууль >20% эсвэл  
 Жигж дэгнүүлт үетэн >15%


Жигж дэгнүүлт үетэн >20%  
 Агь <30%

Агь >30%  
 Жигж дэгнүүлт үетэн <15%


Агь >40%



1. ЧУЛУУРХАГ ХӨРСТЭЙ УУЛЫН ЭНГЭР БОЛОН ЦАВ ТОЛГОДЫН ОРОЙ, ХАЖУУГИЙН ЧУЛУУСАГ АЛАГ ӨВС-БОТУУЛЬТ УУЛЫН ХЭЭРИЙН БЭЛЧЭЭР




1. ЧУЛУУРХАГ ХӨРСТЭЙ УУЛЫН ЭНГЭР БОЛОН ЦАВ ТОЛГОДЫН ОРОЙ, ХАЖУУГИЙН ЧУЛУУСАГ АЛАГ ӨВС-БОТУУЛЬТ УУЛЫН ХЭЭРИЙН БЭЛЧЭЭРИЙН ТАРХАЦЫН ЗУРАГ




Таних тэмдэг

- Тархац
- Аймгийн төв
- Аймгийн хил
- Нуур
- Сумын хил



Projection: WGS 1984  
UTM Zone 48N

## 2. ШАВРАНЦАР ХӨРСТЭЙ УУЛЫН ХАЖУУ, БЭЛИЙН АЛАГ ӨВС-ЖИЖИГ ДЭГНҮҮЛТ ҮЕТЭНТ УУЛЫН ХЭЭРИЙН БЭЛЧЭЭР



2. ШАВРАНЦАР ХӨРСТЭЙ УУЛЫН ХАЖУУ, БЭЛИЙН АЛАГ ӨВС-ЖИЖИГ ДЭГНҮҮЛТ ҮЕТЭНТ УУЛЫН ХЭЭРИЙН БЭЛЧЭЭР

1. Соргог төлөв байдал



1.1 Алаг өвс-жижиг дэгнүүлт үетэнт бүлгэмдэл



Том цэцэгт дааган сүүл



Сунагар биелэг



Тагийн гол гэсэр



Турчаниновын яргуй

Дундаж ургац: 1200-1420 кг/га  
Боломжит даац: 73-83 хонин толгой/100га

I

2. Үетэн багассан төлөв байдал



2.1 Ширэг улалж-алаг өвс-жижиг дэгнүүлт үетэнт бүлгэмдэл



Дэрвээн хазаар өвс



Нангиад түнгэ



Буурал гандбадраа

Дундаж ургац: 920-1100 кг/га  
Боломжит даац: 55-67 хонин толгой/100га

II

3. Зонхилогч ургамал өөрчлөгдсөн төлөв байдал



3.1 Үетэн-ширэг улалжит бүлгэмдэл



Ширэг улалж



Крыловын хялгана

Дундаж ургац: 740-830 кг/га  
Боломжит даац: 41-45 хонин толгой/100га

III

4. Доройтсон төлөв байдал



4.1 Доройтлын таниур ургамал бүхий Ширэг улалжит бүлгэмдэл



Адамсын шарилж




Ишгүй гичгэнэ

Дундаж ургац: 710-810 кг/га;  
Боломжит даац: 35-40 хонин толгой/100га


IV

2. ШАВРАНЦАР ХӨРСТЭЙ УУЛЫН ХАЖУУ, БЭЛИЙН  
АЛАГ ӨВС-ЖИЖИГ ДЭГНҮҮЛТ ҮЕТЭНТ УУЛЫН ХЭЭРИЙН БЭЛЧЭЭРИЙН ТАРХАЦЫН ЗУРАГ




Таних тэмдэг

- ★ Аймгийн төв
- Аймгийн хил
- Нуур
- Тархац
- Сумын хил



Projection: WGS 1984  
UTM Zone 48N

### 3. ШАВРАНЦАР ХӨРСТЭЙ УУЛЫН ХАЖУУГИЙН СӨӨГӨН БОРОЛЗГОНО БҮХИЙ УЛАЛЖ-ҮЕТЭН-БАЯЛАГ АЛАГ ӨВСТ НУГЫН ХЭЭРИЙН БЭЛЧЭЭР



### 3. ШАВРАНЦАР ХӨРСТЭЙ УУЛЫН ХАЖУУГИЙН СӨӨГӨН БОРОЛЗГОНО БҮХИЙ УЛАЛЖ-ҮЕТЭН-БАЯЛАГ АЛАГ ӨВСТ НУГЫН ХЭЭРИЙН БЭЛЧЭЭР

#### 1. Алаг өвс зонхилсон соргог төлөв байдал



1.1 Улалж-үетэн-баялаг алаг өвст бүлгэмдэл



Эмийн сөд



Жинхэнэ өрөмтүүл



Сөөгөн боролзгоно



Соргүй согоовор

Дундаж ургац: 1300-1450 кг/га  
Боломжит даац: 77-88 хонин толгой/100га

I

#### 2. Хуурайшсан төлөв байдал



2.1 Үетэн-алаг өвс-түнгэт бүлгэмдэл



Нангиад түнгэ



Дэrvээн хазаар өвс



Цагаан уул



Марал навчит гичгэнэ

Дундаж ургац: 850-1000 кг/га  
Боломжит даац: 49-60 хонин толгой/100га

II

#### 3. Доройтсон төлөв байдал



3.1 Шарилж-түнгэ-ширэг улалжит бүлгэмдэл



Ширэг улалж



Саарал шарилж




Ишгэн шарилж

Дундаж ургац: 400-850 кг/га  
Боломжит даац: 35-45 хонин толгой/100га


III

3. ШАВРАНЦАР ХӨРСТЭЙ УУЛЫН ХАЖУУГИЙН СӨӨГӨН БОРОЛЗГОНО БҮХИЙ  
УЛАЛЖ-ҮЕТЭН-БАЯЛАГ АЛАГ ӨВСТ НУГЫН ХЭЭРИЙН БЭЛЧЭЭРИЙН ТАРХАЦЫН ЗУРАГ



Таних тэмдэг


- Тархац
- Аймгийн төв
- Аймгийн хил
- Нуур
- Сумын хил




Projection: WGS 1984  
UTM Zone 48N




### 4. ШАВРАНЦАР ХӨРСТЭЙ УУЛЫН БЭЛ, ХӨНДИЙН АЛАГ ӨВС-БАЙГАЛЫН ХЯЛГАНАТ НУГЫН ХЭЭРИЙН БЭЛЧЭЭР



4. ШАВРАНЦАР ХӨРСТЭЙ УУЛЫН БЭЛ, УУЛ ХООРОНДЫН ТЭГШИВТЭР ХӨНДИЙН АЛАГ ӨВС-БАЙГАЛЬ ХЯЛГАНАТ НУГЫН ХЭЭРИЙН БЭЛЧЭЭР




4. ШАВРАНЦАР ХӨРСТЭЙ УУЛЫН БЭЛ, УУЛ ХООРОНДЫН ТЭГШИВТЭР ХӨНДИЙН АЛАГ ӨВС-БАЙГАЛЬ ХЯЛГАНАТ НУГЫН ХЭЭРИЙН БЭЛЧЭЭРИЙН ТАРХАЦЫН ЗУРАГ



Таних тэмдэг

- ★ Аймгийн төв
- Аймгийн хил
- Нуур
- Тархац
- Сумын хил




Projection: WGS 1984  
UTM Zone 48N


5. ГОЛЫН ТАТМЫН АЛАГ ӨВС-ҮЕТЭНТ НУГЫН БЭЛЧЭЭР



5. ГОЛЫН ТАТМЫН АЛАГ ӨВС-ҮЕТЭНТ НУГЫН БЭЛЧЭЭР



5. ГОЛЫН ТАТМЫН АЛАГ ӨВС-ҮЕТЭНТ НУГЫН БЭЛЧЭЭРИЙН ТАРХАЦЫН ЗУРАГ



Таних тэмдэг

- Тархац
- Аймгийн төв
- Аймгийн хил
- Нуур
- Сумын хил

0 125 250 500 Km



Projection: WGS 1984  
UTM Zone 48N

## ХУУРАЙ ХЭЭРИЙН БҮС

ЧУЛУУРХАГ  
ХӨРСТЭЙ УУЛ,  
ТОЛГОДЫН ОРОЙ  
БОЛОН ЭНГЭР  
ХАЖУУГИЙН

6. Чулуусаг алаг  
өвс-жигжиг дэгнүүлт  
үетэн-крыловын  
хялганат бэлчээр

ХӨНГӨН  
ШАВРАНЦАР  
ХӨРСТЭЙ УУЛЫН  
ХАЖУУ, ЦАВ  
ТОЛГОДЫН

7. Үетэн-крыловын  
хялганат бэлчээр

ЭЛСЭНЦЭР  
ХӨРСТЭЙ УХАА  
ГҮВЭЭТ ТАЛ  
ГАЗРЫН

8. Харгана бүхий  
Үетэн-крыловын  
хялганат бэлчээр

ЭЛСЭНЦЭР  
ХӨРСТЭЙ  
ТЭГШ ТАЛ ГАЗРЫН

9. Алаг өвс-түнгэ-  
том хялганат бэлчээр

ЭЛСЭНЦЭР  
ХӨРСТЭЙ  
ТЭГШ ТАЛ ГАЗРЫН

10. Дэрст цайдмын  
бэлчээр

## 6. ЧУЛУУРХАГ ХӨРСТЭЙ УУЛЫН ОРОЙ, ЭНГЭР ХАЖУУГИЙН ЧУЛУУСАГ АЛАГ ӨВС-ЖИЖИГ ДЭГНҮҮЛТ ҮЕТЭН-КРЫЛОВЫН ХЯЛГАНАТ ХУУРАЙ ХЭЭРИЙН БЭЛЧЭЭР

Төлөв байдал	Зонхилогч ургамал	Үндсэн шалгуур	
<p>I 1. Үетэн зонхилсон төлөв байдал I</p> <p>1.1 Чулуусаг алаг өвс-жижиг дэгнүүлт үетэн-крыловын хялганат бүлгэмдэл</p>	<p>Зонхилогч: Крыловын хялгана Дэд зонхилогч: Саман ерхөг, Дэрвээн хазаар өвс, Ленийн ботууль Хялгасан дэвхэргийн цагаан, Бууралдуу янгиц, Говийн ганга, Буурал далантовч</p>	<p>Крыловын хялгана &gt;25% Үетэн &gt;25%</p>	<p>Крыловын хялгана &gt;35% Үетэн &gt;35%</p>
<p>II 2. Үетэн багассан төлөв байдал II</p> <p>2.1 Үетэн-агь-крыловын хялганат бүлгэмдэл</p>	<p>Зонхилогч: Крыловын хялгана Дэд зонхилогч: Агь, Саман ерхөг, Дэрвээн хазаар өвс, Бүхэл навчит багдай</p>	<p>Үетэн &lt; 25%</p>	<p>Үетэн &lt;35%</p>
<p>III 3. Доройтсон төлөв байдал III</p> <p>3.1 Цөөн наст ургамал бүхий Үетэн-агьт бүлгэмдэл</p>	<p>Зонхилогч: Агь Дэд зонхилогч: Крыловын хялгана, Дэрвээн хазаар өвс, Толгодын бударгана, Ямаан шарилж, Бүхэл навчит багдай</p>	<p>Заримдаг сөөгөнцөр&gt;25%</p>	<p>Заримдаг сөөгөнцөр&gt;35%</p>



6. ЧУЛУУРХАГ ХӨРСТЭЙ УУЛЫН ОРОЙ, ЭНГЭР ХАЖУУГИЙН  
ЧУЛУУСАГ АЛАГ ӨВС-ЖИЖИГ ДЭГНҮҮЛТ ҮЕТЭН-КРЫЛОВЫН ХЯЛГАНАТ ХУУРАЙ ХЭЭРИЙН БЭЛЧЭЭР

1. Үетэн зонхилсон төлөв байдал



1.1 Чулуусаг алаг өвс-жижиг дэгнүүлт үетэн-крыловын хялганат бүлгэмдэл



Крыловын хялгана

Говийн ганга



Саман ерхөг

Бууралдуу янгиг

Дундаж ургац: 760-808 кг/га;  
Боломжит даац: 41-44 хонин толгой/100га

I

2. Үетэн багассан төлөв байдал



2.1 Үетэн-агь-крыловын хялганат бүлгэмдэл



Дэрвээн хазаар өвс



Дэлхээ тогторгоно

Дундаж ургац: 660-750 кг/га  
Боломжит даац: 33-38 хонин толгой/100га

II

3. Доройтсон төлөв байдал



3.1 Цөөн наст ургамал бүхий Үетэн-агьт бүлгэмдэл



Агь



Бүхэл навчит багдай



Толгодын бударгана




Ямаан шарилж


Дундаж ургац: 330-380 кг/га  
Боломжит даац: 16-19 хонин толгой/100га

III

6. ЧУЛУУРХАГ ХӨРСТЭЙ УУЛЫН ОРОЙ, ЭНГЭР ХАЖУУГИЙН  
 ЧУЛУУСАГ АЛАГ ӨВС-ЖИЖИГ ДЭГНҮҮЛТ ҮЕТЭН-КРЫЛОВЫН ХЯЛГАНАТ ХУУРАЙ ХЭЭРИЙН БЭЛЧЭЭРИЙН ТАРХАЦЫН ЗУРАГ



- Таних тэмдэг**
- Тархац
  - Аймгийн төв
  - Аймгийн хил
  - Нуур
  - Сумын хил



Projection: WGS 1984  
 UTM Zone 48N

### 7. ХӨНГӨН ШАВРАНЦАР ХӨРСТЭЙ УУЛЫН ХАЖУУ, ЦАВ ТОЛГОДЫН ҮЕТЭН-КРЫЛОВЫН ХЯЛГАНАТ ХУУРАЙ ХЭЭРИЙН БЭЛЧЭЭР

Төлөв байдал	Зонхилогч ургамал	Үндсэн шалгуур
<p>I 1. Крыловын хялгана зонхилсон төлөв байдал I</p> <p>1.1 Үетэн-крыловын хялганат бүлгэмдэл</p> <p>1.2 Агь-крыловын хялгана-үетэнт бүлгэмдэл</p>	<p>Зонхилогч: Крыловын хялгана Дэд зонхилогч: Дэрвээн хазаар өвс, Саман ерхөг, Нангиад түнгэ</p>	<p>Крыловын хялгана &gt;20% Үетэн &gt; 15% Агь &lt;10%</p> <p>Крыловын хялгана &gt;30% эсвэл Үетэн &gt; 20% Агь &lt;20%</p>
<p>III 2. Сийрэгжсэн үетэнт төлөв байдал II</p> <p>2.1 Ширэг улалж-агь-үетэнт бүлгэмдэл</p>	<p>Зонхилогч: Дэрвээн хазаар өвс, Нангиад түнгэ Дэд зонхилогч: Агь, Ширэг улалж, Дагуур хатны цэцэг, Бүхэл навчит багдай</p>	<p>Үетэн&gt;10% Агь &gt;10% Ширэг улалж &lt; 10%</p> <p>Үетэн &lt; 20% Агь &gt;20% Ширэг улалж &lt; 20%</p>
<p>IV 3. Агь зонхилсон төлөв байдал III</p> <p>3.1 Үетэн-ширэг улалж-агьт эсвэл дэлхээ тогторгонот бүлгэмдэл</p>	<p>Зонхилогч: Агь, Дэлхээ тогторгоно Дэд зонхилогч: Ширэг улалж, Нангиад түнгэ, Дэрвээн хазаар өвс</p>	<p>Агь &gt; 20% Ширэг улалж &gt;15% Үетэн &lt; 10%</p> <p>Агь &gt; 40% Ширэг улалж &gt;30% Үетэн &lt; 15%</p>
<p>V 4. Доройтсон төлөв байдал IV</p> <p>4.1 Доройтлын таниур ургамал бүхий Ширэг улалж – шарилжит бүлгэмдэл</p>	<p>Зонхилогч: Адамсын шарилж, Агь Дэд зонхилогч: Ширэг улалж, Амманы сэдэргэнэ, Налчгар хэрээн хошуу, Толгодын бударгана, Ногоон лууль, Имт гичгэнэ, Алтайн согсоолж</p>	<p>Агь &gt;20% Адамсын шарилж&gt;25%</p> <p>Агь&gt;40% эсвэл Адамсын шарилж&gt;50%</p>

7. ХӨНГӨН ШАВРАНЦАР ХӨРСТЭЙ УУЛЫН ХАЖУУ, ЦАВ ТОЛГОДЫН  
 ҮЕТЭН-КРЫЛОВЫН ХЯЛГАНАТ ХУУРАЙ ХЭЭРИЙН БЭЛЧЭЭР

1. Крыловын хялгана зонхилсон төлөв байдал



1.1 Үетэн-крыловын хялганат бүлгэмдэл



Крыловын хялгана



Дагуур хатны цэцэг

Дундаж ургац: 890-1000 кг/га;  
 Боломжит даац: 30-34 хонин толгой/100га

**I**

2. Сийрэгжсэн үетэнт төлөв байдал



3.1 Ширэг улалж-агь-үетэнт бүлгэмдэл



Дэрвээн хазаар өвс    Нангиад түнгэ



Ширэг улалж

Дундаж ургац: 550-620 кг/га;  
 Боломжит даац: 30-34 хонин толгой/100га

**II**

3. Агь эсвэл тогторгоно зонхилсон төлөв байдал



3.1 Үетэн-ширэг улалж-агьт бүлгэмдэл



Агь



Дэлхээ тогторгоно

Дундаж ургац: 370-425 кг/га;  
 Боломжит даац: 18-21 хонин толгой/100га

**III**

4. Шарилжит доройтсон төлөв байдал



4.1 Ширэг улалж – шарилжит бүлгэмдэл



Адамсын шарилж




Амманы сэдэргэнэ


Дундаж ургац: 370-425 кг/га;  
 Боломжит даац: 18-21 хонин толгой/100га

**IV**

7. ХӨНГӨН ШАВРАНЦАР ХӨРСТЭЙ УУЛЫН ХАЖУУ, ЦАВ ТОЛГОДЫН  
 ҮЕТЭН-КРЫЛОВЫН ХЯЛГАНАТ ХУУРАЙ ХЭЭРИЙН БЭЛЧЭЭРИЙН ТАРХАЦЫН ЗУРАГ



- Таних тэмдэг**
- Тархац
  - Аймгийн төв
  - Аймгийн хил
  - Нуур
  - Сумын хил




Projection: WGS 1984  
 UTM Zone 48N


### 8. ЭЛСЭНЦЭР ХӨРСТЭЙ УХАА ГҮВЭЭТ ТАЛ ГАЗРЫН ХАРГАНА БҮХИЙ ҮЕТЭН-КРЫЛОВЫН ХЯЛГАНАТ ХУУРАЙ ХЭЭРИЙН БЭЛЧЭЭР

Төлөв байдал	Зонхилогч ургамал	Үндсэн шалгуур	
<p>I 1. Үетэн зонхилсон төлөв байдал</p> <p>1.1 Харгана бүхий Үетэн-крыловын хялганат бүлгэмдэл</p>	<p>Зонхилогч: Крыловын хялгана Дэд зонхилогч: Дэрвээн хазаар өвс, Нангиад түнгэ, Жижиг навчит харгана, Нарийн навчит харгана</p>	<p>Крыловын хялгана &gt; 20% Үетэн &gt; 15% Харгана &gt; 10%</p>	<p>Крыловын хялгана &gt; 30% Үетэн &gt; 20% Харгана &gt; 10%</p>
<p>II 2. Үетэн багассан төлөв байдал</p> <p>2.1 Харгана-крыловын хялганат бүлгэмдэл</p> <p>2.2 Ширэг улалж-дэрвээн хазаар өвс-крыловын хялганат бүлгэмдэл</p>	<p>Зонхилогч: Крыловын хялгана Дэд зонхилогч: Жижиг навчит харгана, Нарийн навчит харгана, Ширэг улалж, Дэрвээн хазаар өвс, Нангиад түнгэ</p>	<p>Крыловын хялгана &gt; 15% Үетэн &gt; 10% Харгана &gt; 15% Улалж &gt; 10%</p>	<p>Крыловын хялгана &gt; 20% Үетэн &gt; 15% Харгана &gt; 15% Улалж &gt; 20%</p>
<p>IV 3. Зонхилогч ургамал өөрчлөгдсөн төлөв байдал</p> <p>3.1 Цөөн наст бүхий Үетэн-агь-харганат</p> <p>3.2 Үетэн-ширэг улалжит бүлгэмдэл</p>	<p>Зонхилогч: Жижиг навчит харгана, Нарийн навчит харгана, Ширэг улалж Дэд зонхилогч: Агь, Дэрвээн хазаар өвс, Нангиад түнгэ, Крыловын хялгана</p>	<p>Үетэн &gt; 10% Харгана &gt; 20% Улалж &gt; 20% Цөөн наст &gt; 10%</p>	<p>Үетэн &gt; 15% Харгана &gt; 20% Улалж &gt; 40% Цөөн наст &gt; 10%</p>
<p>V 4. Доройтсон төлөв байдал</p> <p>4.1 Ширэг улалж-харганат бүлгэмдэл</p> <p>4.2 Ширэг улалж-шарилжит бүлгэмдэл</p>	<p>Зонхилогч: Жижиг навчит харгана, Адамсын шарилж Дэд зонхилогч: Ширэг улалж, Имт гичгэнэ</p>	<p>Улалж &gt; 20% Шарилж &gt; 20%</p>	<p>Улалж &gt; 40% Шарилж &gt; 30%</p>
<p>V 5. Хүчтэй доройтсон төлөв байдал</p> <p>5.1 Цөөн наст бүхий Харганат бүлгэмдэл</p>	<p>Зонхилогч: Жижиг навчит харгана Толгодын бударгана, Ногоон лууль, Цагаан лууль, Шоргор лууль, Шүлхий шарилж, Ямаан шарилж, Монгол хамхаг</p>	<p>Харгана &gt; 20% Цөөн наст &gt; 20%</p>	<p>Харгана &gt; 20% Цөөн наст &gt; 20%</p>

8. ЭЛСЭНЦЭР ХӨРСТЭЙ УХАА ГҮВЭЭТ ТАЛ ГАЗРЫН  
ХАРГАНА БҮХИЙ ҮЕТЭН-КРЫЛОВЫН ХЯЛГАНАТ ХУУРАЙ ХЭЭРИЙН БЭЛЧЭЭР



8. ЭЛСЭНЦЭР ХӨРСТЭЙ УХАА ГҮВЭЭТ ТАЛ ГАЗРЫН  
ХАРГАНА БҮХИЙ ҮЕТЭН-КРЫЛОВЫН ХЯЛГАНАТ ХУУРАЙ ХЭЭРИЙН БЭЛЧЭЭРИЙН ТАРХАЦЫН ЗУРАГ



Таних тэмдэг

- Тархац
- Аймгийн төв
- Аймгийн хил
- Нуур
- Сумын хил

0 125 250 500 Km




Projection: WGS 1984  
UTM Zone 48N




### 9. ЭЛСЭНЦЭР ХӨРСТЭЙ ТЭГШ ТАЛ ГАЗРЫН АЛАГ ӨВС – ТҮНГЭ – ТОМ ХЯЛГАНАТ ХУУРАЙ ХЭЭРИЙН БЭЛЧЭЭР

Төлөв байдал	Зонхилогч ургамал	Үндсэн шалгуур	
<p>I   1. Соргог төлөв байдал   I</p> <p>1.1 Алаг өвс – түнгэ – том хялганат бүлгэмдэл</p>	<p>Зонхилогч: Том хялгана Дэд зонхилогч: Нангиад түнгэ, Дэрвээн дааган сүүл, Марал навчит гичгэнэ, Хонгорзулархуу хонгорзалаа, Хижээл сонгино, Дагуур хүж өвс</p>	<p>Том хялгана &gt;25% Нангиад түнгэ &gt;20% Алаг өвс &gt;20%</p>	<p>Том хялгана &gt;35% Нангиад түнгэ &gt;30% Алаг өвс &gt;25%</p>
<p>III   2. Алаг өвс багассан төлөв байдал   II</p> <p>2.1 Түнгэ – том хялганат бүлгэмдэл</p> <p>2.2 Дэрвээн хазаар өвс-том хялганат бүлгэмдэл</p>	<p>Зонхилогч: Том хялгана Дэд зонхилогч: Дэрвээн хазаар өвс, Нангиад түнгэ, Хонгорзулархуу хонгорзалаа</p>	<p>Том хялгана &gt;25% Нангиад түнгэ &gt; 15% Дэрвээн хазаар өвс &gt; 15%</p>	<p>Том хялгана &gt;35% Нангиад түнгэ &gt; 20% Дэрвээн хазаар өвс &gt; 20%</p>
<p>IV   3. Том хялгана багассан төлөв байдал   III</p> <p>3.1 Том хялгана-агь-үетэнт бүлгэмдэл</p>	<p>Зонхилогч: Дэрвээн хазаар өвс, Нангиад түнгэ Дэд зонхилогч: Агь, Том хялгана, Ширэг улалж</p>	<p>Үетэн &gt; 20% Агь &gt; 20% Том хялгана &lt;15%</p>	<p>Үетэн &gt; 30% Агь &gt; 40% Том хялгана &lt;20%</p>
<p>V   4. Доройтсон төлөв байдал   IV</p> <p>4.1 Доройтлын таниур ургамал бүхий бүлгэмдэл</p> <p>4.2 Цөөн наст ургамал бүхий Зээргэнэт бүлгэмдэл</p>	<p>Зонхилогч: Агь, Нангиад зээргэнэ, Дэлхээ тогторгоно, Адамсын шарилж, Ширэг улалж, Имт гичгэнэ, Амманы сэдэргэнэ, Ногоон лууль, Шоргор лууль, Толгодын бударгана</p>	<p>Доройтлын таниур ургамлууд зонхилно.</p>	<p>Доройтлын таниур ургамлууд зонхилно.</p>

9. ЭЛСЭНЦЭР ХӨРСТЭЙ ТЭГШ ТАЛ ГАЗРЫН  
АЛАГ ӨВС – ТҮНГЭ – ТОМ ХЯЛГАНАТ ХУУРАЙ ХЭЭРИЙН БЭЛЧЭЭР



9. ЭЛСЭНЦЭР ХӨРСТЭЙ ТЭГШ ТАЛ ГАЗРЫН  
АЛАГ ӨВС – ТҮНГЭ – ТОМ ХЯЛГАНАТ ХУУРАЙ ХЭЭРИЙН БЭЛЧЭЭРИЙН ТАРХАЦЫН ЗУРАГ



Таних тэмдэг


- Тархац
- Аймгийн төв
- Аймгийн хил
- Нуур
- Сумын хил

0 125 250 500 Km




Projection: WGS 1984  
UTM Zone 48N


### 10. НАМ ДОР ГАЗРЫН ДЭРСТ ЦАЙДМЫН БЭЛЧЭЭР



## 10. НАМ ДОР ГАЗРЫН ДЭРСТ ЦАЙДМЫН БЭЛЧЭЭР



10. НАМ ДОР ГАЗРЫН ДЭРСТ ЦАЙДМЫН БЭЛЧЭЭРИЙН ТАРХАЦЫН ЗУРАГ



## ЦӨЛӨРХӨГ ХЭЭРИЙН БҮС

ХАЙРГА-  
ЧУЛУУРХАГ  
ХӨРСТЭЙ НАМ  
УУЛС, ТОЛГОДЫН

ЭЛСЭНЦЭР  
ХӨРСТЭЙ ТАЛ  
ГАЗРЫН

МАРААЛАГ  
ШАВАРЛАГ  
ХӨРСТЭЙ ТАЛ  
ГАЗРЫН

ХУЖИР,  
МАРААЛАГ  
ХӨРСТЭЙ ХОТОС,  
НАМ ДОР ГАЗРЫН

ХАГАС БЭХЭЖСЭН  
ЭЛСЭН ДЭЭРХ

11. Заримдаг  
сөөгөнцөр-өдлөг  
хялганат цөлийн  
хээрийн бэлчээр


12. Сөөг-таана-  
үетэн-өдлөг хялганат  
цөлийн хээрийн  
бэлчээр

13. Таана-заримдаг  
сөөгөнцөр-өдлөг  
хялганат цөлийн  
хээрийн бэлчээр

14. Шар, улаан  
бударгана-дэрст  
цайдмын бэлчээр
















15. Хагас бэхэжсэн  
элсэн дээрх Хар  
султ бэлчээр

### 11. ХАЙРГА-ЧУЛУУРХАГ ХӨРСТЭЙ НАМ УУЛС, ТОЛГОДЫН ЗАРИМДАГ СӨӨГӨНЦӨР-ӨДЛӨГ ХЯЛГАНАТ ЦӨЛИЙН ХЭЭРИЙН БЭЛЧЭЭР






### 11. ХАЙРГА-ЧУЛУУРХАГ ХӨРСТЭЙ НАМ УУЛС, ТОЛГОДЫН ЗАРИМДАГ СӨӨГӨНЦӨР-ӨДЛӨГ ХЯЛГАНАТ ЦӨЛИЙН ХЭЭРИЙН БЭЛЧЭЭР


1. Өдлөг хялгана зонхилсон төлөв байдал	2. Өдлөг хялгана багассан төлөв байдал	3. Доройтсон төлөв байдал
		
<p>1.1 Заримдаг сөөгөнцөр-өдлөг хялганат бүлгэмдэл</p>	<p>2.2 Өдлөг хялгана-заримдаг сөөгөнцөр-таанат бүлгэмдэл</p>	<p>3.1 Цөөн наст бүхий Таанат бүлгэмдэл</p>
<div style="display: flex; justify-content: space-around;">   </div>	<div style="display: flex; justify-content: space-around;">   </div>	<div style="display: flex; justify-content: space-around;">   </div>
<p>Говийн хялгана      Төлөгчдүү боролз</p>	<p>Ахар навчит баглуур      Бор бударгана</p>	<p>Таана      Шүлхий шарилж</p>
<div style="display: flex; justify-content: space-around;">   </div>	<div style="display: flex; justify-content: space-around;">   </div>	<div style="display: flex; justify-content: space-around;">   </div>
<p>Орог тэсэг      Шаргал шарилж</p>	<p>Агь      Таана</p>	<p>Ямаан шарилж      Бага хургалж</p>
<p>Дундаж ургац: 200-350 кг/га Боломжит даац: 12-21 хонин толгой/100га <b>I</b></p>	<p>Дундаж ургац: 270-400 кг/га Боломжит даац: 15-22 хонин толгой/100га <b>II</b></p>	<p>Дундаж ургац: 450-530 кг/га Боломжит даац: 22-27 хонин толгой/100га <b>IV</b></p>

11. ХАЙРГА-ЧУЛУУРХАГ ХӨРСТЭЙ НАМ УУЛС, ТОЛГОДЫН  
 ЗАРИМДАГ СӨӨГӨНЦӨР-ӨДЛӨГ ХЯЛГАНАТ ЦӨЛИЙН ХЭЭРИЙН БЭЛЧЭЭРИЙН ТАРХАЦЫН ЗУРАГ



Таних тэмдэг

- Тархац
- Аймгийн төв
- Аймгийн хил
- Нуур
- Сумын хил




Projection: WGS 1984  
 UTM Zone 48N


## 12. ЭЛСЭНЦЭР ХӨРСТЭЙ ТАЛ ГАЗРЫН СӨӨГ-ТААНА-ҮЕТЭН-ӨДЛӨГ ХЯЛГАНАТ ЦӨЛИЙН ХЭЭРИЙН БЭЛЧЭЭР

Төлөв байдал	Зонхилогч ургамал	Үндсэн шалгуур	
<p>I   1. Өдлөг хялгана зонхилсон төлөв байдал   I</p> <p>1.1 Сөөг-таана-үетэн-өдлөг хялганат бүлгэмдэл</p>	<p>Зонхилогч: Говийн болон Сайрын хялгана, Клеменцийн хялгана Дэд зонхилогч: Зүүнгарын хазаар өвс, Таана, Улаан харгана, Одой харгана, Орог тэсэг, Шар хотир</p>	<p>Өдлөг хялгана 10-15% Үетэн 3-5% Таана 3-5% Сөөг &lt; 4%</p>	<p>Өдлөг хялгана &gt;15% Үетэн &gt;3% Таана &gt;3% Сөөг &lt; 4%</p>
<p>III   2. Үетэн багассан төлөв байдал   II</p> <p>2.1 Таана-өдлөг хялганат бүлгэмдэл</p> <p>2.2 Шарилж-өдлөг хялганат бүлгэмдэл</p>	<p>Зонхилогч: Говийн болон Сайрын хялгана, Клеменцийн хялгана Дэд зонхилогч: Агь, Хуурайсаг шарилж, Таана Оролцогч: Зүүнгарын хазаар өвс, Дэрвээн тогторгоно, Улаан харгана, Орог тэсэг, Амманийн сэдэргэнэ</p>	<p>Өдлөг хялгана 8-10% Таана 5-10% Шарилж 5-8%</p>	<p>Өдлөг хялгана &lt;15% Таана &gt;10% Шарилж &gt;5%</p>
<p>III-IV   3. Зонхилогчид солигдсон төлөв байдал   III</p> <p>3.1 Үетэн-агьт бүлгэмдэл</p> <p>3.2 Хазаар өвс-өдлөг хялгана-таанат бүлгэмдэл</p>	<p>Зонхилогч: Агь, Таана Дэд зонхилогч: Говийн болон Сайрын хялгана, Зүүнгарын хазаар өвс Оролцогч: Амманийн сэдэргэнэ, Улаан харгана, Дэрвээн тогторгоно</p>	<p>Таана &gt;10% Шарилж &gt; 10% Өдлөг хялгана &lt;8%</p>	<p>Таана &gt;15% Шарилж &gt; 10% Өдлөг хялгана &lt;10%</p>
<p>V   4. Доройтсон төлөв байдал   IV</p> <p>4.1 Доройтлын таниур ургамал бүхий Таанат бүлгэмдэл</p> <p>4.2 Цөөн настын бүлгэмдэл</p>	<p>Зонхилогч: Таана, Толгодын бударгана, Шоргор лууль, Шүлхий шарилж, Ямаан шарилж, Бага хургалж Оролцогч: Амманийн сэдэргэнэ, Адамсын шарилж, Арзгар согсоолж</p>	<p>Таана &gt;8% Доройтлын таниур ургамал &gt;10%</p>	<p>Таана &gt;15% Доройтлын таниур ургамал &gt;10%</p>

## 12. ЭЛСЭНЦЭР ХӨРСТЭЙ ТАЛ ГАЗРЫН СӨӨГ-ТААНА-ҮЕТЭН-ӨДЛӨГ ХЯЛГАНАТ ЦӨЛИЙН ХЭЭРИЙН БЭЛЧЭЭР



12. ЭЛСЭНЦЭР ХӨРСТЭЙ ТАЛ ГАЗРЫН  
СӨӨГ-ТААНА-ҮЕТЭН-ӨДЛӨГ ХЯЛГАНАТ ЦӨЛИЙН ХЭЭРИЙН БЭЛЧЭЭРИЙН ТАРХАЦЫН ЗУРАГ



Таних тэмдэг


- ★ Аймгийн төв
- Аймгийн хил
- Нуур
- Тархац
- Сумын хил

0 125 250 500 Km




Projection: WGS 1984  
UTM Zone 48N


### 13. МАРААЛАГ, ШАВРАНЦАР ХӨРСТЭЙ ТАЛ ГАЗРЫН ТААНА-ЗАРИМДАГ СӨӨГӨНЦӨР-ӨДЛӨГ ХЯЛГАНАТ ЦӨЛИЙН ХЭЭРИЙН БЭЛЧЭЭР



13. МАРААЛАГ, ШАВРАНЦАР ХӨРСТЭЙ ТАЛ ГАЗРЫН  
ТААНА-ЗАРИМДАГ СӨӨГӨНЦӨР-ӨДЛӨГ ХЯЛГАНАТ ЦӨЛИЙН ХЭЭРИЙН БЭЛЧЭЭР




13. МАРААЛАГ, ШАВРАНЦАР ХӨРСТЭЙ ТАЛ ГАЗРЫН  
ТААНА-ЗАРИМДАГ СӨӨГӨНЦӨР-ӨДЛӨГ ХЯЛГАНАТ ЦӨЛИЙН ХЭЭРИЙН БЭЛЧЭЭРИЙН ТАРХАЦЫН ЗУРАГ



Таних тэмдэг

- Тархац
- Аймгийн төв
- Аймгийн хил
- Нуур
- Сумын хил




Projection: WGS 1984  
UTM Zone 48N



### 14. ХУЖИР, МАРААЛАГ ХӨРСТЭЙ ХОТОС, НАМ ДОР ГАЗРЫН ШАР, УЛААН БУДАРГАНА-ДЭРСТ ЦАЙДМЫН БЭЛЧЭЭР

Төлөв байдал



Зонхилогч ургамал

*Зонхилогч: Гялгар дэрс  
Дэд зонхилогч: Шар бударгана,  
Улаан бударгана  
Оролцогч: Сибирь хармаг, Таана,  
Хөмүүл, Бага хургалж, Хоног будаа*

*Зонхилогч: Гялгар дэрс  
Дэд зонхилогч: Улаан бударгана, Таана  
Оролцогч: Шар бударгана, Сибирь  
хармаг, Хөмүүл, Бага хургалж, Хоног  
будаа*

Үндсэн шалгуур

Дэрс 10-30%  
Бударгана 5-10%  
Бусад ургамал <10%

Дэрс >15%  
Бударгана >5%  
Бусад ургамал <10%

Дэрс 10-15%  
Бударгана 5-10%  
Бусад ургамал <10%

Дэрс >10%  
Бударгана 5-10%  
Бусад ургамал <10%

Хөрсний усны түвшин доошилсон, Дэрс намсаж, амьдармж ба нөхөн сэргэлт муудсан.

14. ХУЖИР, МАРААЛАГ ХӨРСТЭЙ ХОТОС, НАМ ДОР ГАЗРЫН ШАР, УЛААН БУДАРГАНА-ДЭРСТ ЦАЙДМЫН БЭЛЧЭЭР

1. Дэрс зонхилсон төлөв байдал



1.1 Шар, улаан бударгана-дэрст бүлгэмдэл



Гялгар дэрс



Шар бударгана



Хөмүүл

Дундаж ургац: 270-380 кг/га; Боломжит даац: 15-22 хонин толгой/100га



2. Хуурайшсан төлөв байдал



2.1 Улаан бударгана-дэрст бүлгэмдэл



Улаан бударгана



Таана




Хоног будаа

Дундаж ургац: 270-380 кг/га; Боломжит даац: 15-22 хонин толгой/100га



14. ХУЖИР, МАРААЛАГ ХӨРСТЭЙ ХОТОС, НАМ ДОР ГАЗРЫН ШАР, УЛААН БУДАРГАНА-ДЭРСТ ЦАЙДМЫН БЭЛЧЭЭРИЙН ТАРХАЦЫН ЗУРАГ



Таних тэмдэг


- Тархац
- Аймгийн төв
- Аймгийн хил
- Нуур
- Сумын хил

0 125 250 500 Km




Projection: WGS 1984  
UTM Zone 48N


### 15. ХАГАС БЭХЭЖСЭН ЭЛСЭН ДЭЭРХ ХАР СУЛЬТ БЭЛЧЭЭР



15. ХАГАС БЭХЭЖСЭН ЭЛСЭН ДЭЭРХ ХАР СУЛЫТ БЭЛЧЭЭР




15. ХАГАС БЭХЭЖСЭН ЭЛСЭН ДЭЭРХ ХАР СУЛТ БЭЛЧЭЭРИЙН ТАРХАЦЫН ЗУРАГ



Таних тэмдэг

- Тархац
- Аймгийн төв
- Аймгийн хил
- Нуур
- Сумын хил



Projection: WGS 1984  
UTM Zone 48N

## ЦӨЛИЙН БҮС

ХАЙРГА-ЧУЛУУРХАГ  
ГОВИЙН УУЛС,  
ТОЛГОДЫН

16. Баглуур-шар модот  
цөлийн бэлчээр

ХАЙРГА-ЧУЛУУРХАГ  
ГОВИЙН УУЛС,  
ТОЛГОДЫН

17. Заримдаг сөөгөнцөрт  
цөлийн бэлчээр


ХАЙРГА-ЧУЛУУРХАГ  
ГОВИЙН УУЛС,  
ТОЛГОДЫН

18. Өндөр ургасан Загт  
цөлийн бэлчээр

ХАЙРГА-ЧУЛУУРХАГ  
ГОВИЙН УУЛС,  
ТОЛГОДЫН

19. Заг- хармагт цөлийн  
бэлчээр

### 16. ХАЙРГА-ЧУЛУУРХАГ ХӨРСТЭЙ ГОВИЙН УУЛС, ТОЛГОДЫН БАГЛУУР-ШАРМОДОТ ЦӨЛИЙН БЭЛЧЭЭР





### 16. ХАЙРГА-ЧУЛУУРХАГ ХӨРСТЭЙ ГОВИЙН УУЛС, ТОЛГОДЫН БАГЛУУР-ШАРМОДОТ ЦӨЛИЙН БЭЛЧЭЭР


#### 1. Соргог төлөв байдал



1.1 Баглуур-шар модот бүлгэмдэл



Регелийн шар мод



Ахар навчит баглуур



Прежевальскийн зээргэнэ



Гейманы бөөдий

I



#### 2. Сийрэгжсэн төлөв байдал



2.1 Баглуур-шар модот бүлгэмдэл



Шар хотир




Улаан бударгана



Ямаан шарилж

II

16. ХАЙРГА-ЧУЛУУРХАГ ХӨРСТЭЙ ГОВИЙН УУЛС, ТОЛГОДЫН БАГЛУУР-ШАРМОДОТ ЦӨЛИЙН БЭЛЧЭЭРИЙН ТАРХАЦЫН ЗУРАГ



Таних тэмдэг

- Тархац
- Аймгийн төв
- Аймгийн хил
- Нуур
- Сумын хил


0 125 250 500 Km



Projection: WGS 1984  
UTM Zone 48N

### 17. ХАЙРГА ЧУЛУУТ ТАЛ ГАЗРЫН ЗАРИМДАГ СӨӨГӨНЦӨРТ ЦӨЛИЙН БЭЛЧЭЭР

Төлөв байдал



Зонхилогч ургамал

Зонхилогч: Ахар навчит баглуур, Улаан бударгана, Бор бударгана, Заар таар /тус орны баруун хэсэгт/ Оролцогч: Заг, Орог тэсэг, Таана, Шар бударгана, Хүйтсэг шарилж, Ямаан шарилж, Сайрын хялгана, Гейманы бөөдий, Бага хургалж

Зонхилогч: Ахар навчит баглуур, Улаан бударгана, Бор бударгана, Заар таар / тус орны баруун хэсэгт/ Оролцогч: Заг, Орог тэсэг, Таана, Шар бударгана, Ямаан шарилж

Үндсэн шалгуур

Зонхилогч ургамал 10-20%  
Бусад ургамал 5-10%

Зонхилогч ургамал 5-10%  
Бусад ургамал < 5%

Зонхилогч ургамал >10%  
Бусад ургамал >5%

Зонхилогч ургамал <10%  
Бусад ургамал < 5%

### 17. ХАЙРГА ЧУЛУУТ ТАЛ ГАЗРЫН ЗАРИМДАГ СӨӨГӨНЦӨРТ ЦӨЛИЙН БЭЛЧЭЭР

#### 1. Соргог төлөв байдал



1.1 Заримдаг сөөгөнцөрт бүлгэмдэл



Ахар навчит баглуур



Бор бударгана



Зараа таар



Улаан бударгана

I

#### 2. Сийрэгжсэн төлөв байдал



2.1 Заримдаг сөөгөнцөрт бүлгэмдэл



Таана



Гейманы бөөдий




Ямаан шарилж

II




17. ХАЙРГА ЧУЛУУТ ТАЛ ГАЗРЫН ЗАРИМДАГ СӨӨГӨНЦӨРТ ЦӨЛИЙН БЭЛЧЭЭРИЙН ТАРХАЦЫН ЗУРАГ



Таних тэмдэг

- Тархац
- Аймгийн төв
- Аймгийн хил
- Нуур
- Сумын хил



Projection: WGS 1984  
UTM Zone 48N

### 18. БЭХЭЖСЭН БОЛОН ХАГАС БЭХЭЖСЭН ЭЛСЭН ДЭЭРХ ӨНДӨР УРГАСАН ЗАГТ ЦӨЛИЙН БЭЛЧЭЭР



18. БЭХЭЖСЭН БОЛОН ХАГАС БЭХЭЖСЭН ЭЛСЭН ДЭЭРХ  
ӨНДӨР УРГАСАН ЗАГТ ЦӨЛИЙН БЭЛЧЭЭР

1. Соргог төлөв байдал



1.1 Загт бүлгэмдэл



Заг



Монгол азар

I

2. Сийрэгжсэн төлөв байдал




2.1 Загт бүлгэмдэл



Цагаан гоёо

II

18. БЭХЭЖСЭН БОЛОН ХАГАС БЭХЭЖСЭН ЭЛСЭН ДЭЭРХ  
ӨНДӨР УРГАСАН ЗАГТ ЦӨЛИЙН БЭЛЧЭЭРИЙН ТАРХАЦЫН ЗУРАГ



Таних тэмдэг

- Тархац
- Аймгийн төв
- Аймгийн хил
- Нуур
- Сумын хил

0 125 250 500 Km





Projection: WGS 1984  
UTM Zone 48N



### 19. ДАВСАРХАГ ХОТСЫН ХАРМАГТ ЦӨЛИЙН БЭЛЧЭЭР

Төлөв байдал



Зонхилогч ургамал

*Зонхилогч: Сибирь хармаг, говийн баруун хэсэгт Цүндгэр үрт хармаг, Роборовскийн хармаг  
Дэд зонхилогч: Давссаг заг  
Оролцогч: Орос махирс, Гялгар дэрс, Зэгс, Урал чихэр өвс, Зүүнгарын улаан гоёо, Сухай*

*Зонхилогч: Сибирь хармаг, говийн баруун хэсэгт Цүндгэр үрт хармаг, Роборовскийн хармаг  
Дэд зонхилогч: Давссаг заг  
Оролцогч: Орос махирс, Гялгар дэрс, Зэгс, Урал чихэр өвс, Зүүнгарын улаан гоёо, Сухай*

Үндсэн шалгуур

Хармаг 15-35%  
Бусад ургамал <10%

Хармаг 5-25%  
Бусад ургамал <10%

(Өнгөн хөрсний элэгдэл  
эвдрэлийн зэрэглэл > 3)

### 19. ДАВСАРХАГ ХОТСЫН ХАРМАГТ ЦӨЛИЙН БЭЛЧЭЭР

#### 1. Соргог төлөв байдал



1.1 Сибирь хармагт бүлгэмдэл



Сибирь хармаг



Роборовскийн хармаг

I

#### 2. Сийрэгжсэн төлөв байдал



2.1 Сибирь хармагт бүлгэмдэл



Цүндгэр үрт хармаг




Зүүнгарын улаан гоёо


II



19. ДАВСАРХАГ ХОТСЫН ХАРМАГТ ЦӨЛИЙН БЭЛЧЭЭРИЙН ТАРХАЦЫН ЗУРАГ



- Таних тэмдэг**
- Тархац
  - Аймгийн төв
  - Аймгийн хил
  - Нуур
  - Сумын хил



Projection: WGS 1984  
UTM Zone 48N

## ӨНДӨР УУЛЫН БҮСЛҮҮР

МОНГОЛ-АЛТАЙН НУРУУНД  
2650-3200 М ӨНДӨРТ  
УУЛЫН ОРОЙ, ХЯР

20. Жижиг дэгнүүлт үетэн-хүйтсэг  
алаг өвст өндөр уулын хээрийн  
бэлчээр

МОНГОЛ АЛТАЙ  
(2850-3050 М), ХАНГАЙН  
(2520-2850 М) НУРУУНЫ  
ӨНДӨР УУЛЫН БҮСЛҮҮРТ  
ХУУРАЙСАГ НӨХЦӨЛД


21. Хүйтсэг алаг өвс-ботуульт өндөр  
уулын хээрийн бэлчээр

МОНГОЛ АЛТАЙН  
(2300-2600 М) НУРУУНД  
ЧИЙГСЭГ НӨХЦӨЛД

22.Сөөг бүхий хуурайсуу-чийгсэг  
алаг өвс-том дэгнүүлт үетэнт өндөр  
уулын нугын бэлчээр

## 20. ЖИЖИГ ДЭГНҮҮЛТ ҮЕТЭН-ХҮЙТСЭГ АЛАГ ӨВСТ ӨНДӨР УУЛЫН ХЭЭРИЙН ХАЙРГА-ЧУЛУУТ БЭЛЧЭЭР

### Төлөв байдал



### Зонхилогч ургамал

*Зонхилогч: Дэрэн ажигана, Цасархуу навчинцарт ортууз, Цөөн цэцэгт ортууз, Мейерийн дэвхэргийн цагаан, Хадны бөгтөргөнө*  
*Дэд зонхилогч: Ленийн ботууль, Алтайн дааган сүүл, Сунагар биелэг, Алтайн бутнуур*

*Зонхилогч: Мөнгөлөг навчит шарилж, Үндэсэрхэг шарилж*  
*Дэд зонхилогч: Дэрэн ажигана, Хаврын алаглиг цэцэг, Цагаан навчит банздоо, Мейерийн дэвхэргийн цагаан*  
*Оролцогч: Ленийн болон Крыловын ботууль, Саман ерхөг, Алтайн дааган сүүл, Сунагар биелэг*

### Үндсэн шалгуур

Хүйтсэг алаг өвс  
20-30%  
Жижиг дэгнүүлт үетэн  
10-20%

Мөнгөлөг навчит шарилж 10-25%  
Хүйтсэг алаг өвс 10-15%  
Жижиг дэгнүүлт үетэн < 10%

Хүйтсэг алаг өвс >20%  
Жижиг дэгнүүлт үетэн >15%

Мөнгөлөг навчит шарилж >10%  
Хүйтсэг алаг өвс <20%  
Жижиг дэгнүүлт үетэн < 15%

## 20. ЖИЖИГ ДЭГНҮҮЛТ ҮЕТЭН-ХҮЙТСЭГ АЛАГ ӨВСТ ӨНДӨР УУЛЫН ХЭЭРИЙН ХАЙРГА-ЧУЛУУТ БЭЛЧЭЭР

### 1. Соргог төлөв байдал



1.1 Жижиг дэгнүүлт үетэн-хүйтсэг алаг өвст бүлгэмдэл



Цасархуу навчинцарт ортууз



Алтайн дааган сүүл



Ленийн ботууль



Цөөн цэцэгт ортууз

I



### 2. Шарилж зонхилсон төлөв байдал



2.1 Хүйтсэг алаг өвс-шарилжит бүлгэмдэл



Мөнгөлөг навчит шарилж



Үндэсэрхэг шарилж




Мейерийн дэвхэргийн цагаан



Дэрэн ажигана



III

20. ЖИЖИГ ДЭГНУУЛТ ҮЕТЭН-ХҮЙТСЭГ АЛАГ ӨВСТ  
ӨНДӨР УУЛЫН ХЭЭРИЙН ХАЙРГА-ЧУЛУУТ БЭЛЧЭЭРИЙН ТАРХАЦЫН ЗУРАГ




Таних тэмдэг

- Тархац
- Аймгийн төв
- Аймгийн хил
- Нуур
- Сумын хил



Projection: WGS 1984  
UTM Zone 48N

## 21. ЧУЛУУРХАГ ХӨРСТЭЙ ХҮЙТСЭГ АЛАГ ӨВС-БОТУУЛЬТ ӨНДӨР УУЛЫН ХЭЭРИЙН БЭЛЧЭЭР





## 21. ЧУЛУУРХАГ ХӨРСТЭЙ ХҮЙТСЭГ АЛАГ ӨВС-БОТУУЛЬТ ӨНДӨР УУЛЫН ХЭЭРИЙН БЭЛЧЭЭР

### 1. Ботууль зонхилсон төлөв байдал



1.1 Хүйтсэг алаг өвс-ботуульт бүлгэмдэл



Крыловын ботууль




Ленийн ботууль



Цасархуу навчинцарт ортууз

I



### 2. Шарилж зонхилсон төлөв байдал



2.1 Жижиг дэгнүүлт үетэн- хүйтсэг алаг өвс-шарилжит бүлгэмдэл



Мөнгөлөг навчит шарилж



Үндэсэрхэг шарилж




Торгон гичгэнэ



Мейерийн дэвхэргийн цагаан


III

21. ЧУЛУУРХАГ ХӨРСТЭЙ ХҮЙТСЭГ АЛАГ ӨВС-БОТУУЛЬТ  
ӨНДӨР УУЛЫН ХЭЭРИЙН БЭЛЧЭЭР



Таних тэмдэг


- Тархац
- Аймгийн төв
- Аймгийн хил
- Нуур
- Сумын хил



Projection: WGS 1984  
UTM Zone 48N

## 22. СӨӨГ БҮХИЙ ХУУРАЙСУУ-ЧИЙГСЭГ АЛАГ ӨВС-ТОМ ДЭГНҮҮЛТ ҮЕТЭНТ ӨНДӨР УУЛЫН НУГЫН БЭЛЧЭЭР

### Төлөв байдал



### Зонхилогч ургамал

*Зонхилогч: Шеллийн бутнуур, Алтайн бутнуур*  
*Дэд зонхилогч: Жинхэнэ өрөмтүүл, Азийн төлөгч өвс, Цагаан дэгд*  
*Оролцогч: Сибирь тошлог, Хар үрт чаргай, Алтан харгана, Бунгийн харгана, Тарваган харгана, Алтайн далан хальс*

*Зонхилогч: Жинхэнэ өрөмтүүл, Азийн төлөгч өвс*  
*Дэд зонхилогч: Шеллийн бутнуур, Алтайн бутнуур*  
*Оролцогч: Сибирь тошлог, Хар үрт чаргай, Алтан харгана, Бунгийн харгана, Тарваган харгана, Алтайн далан хальс*

### Үндсэн шалгуур

Шеллийн бутнуур 25-40%  
 Алаг өвс 25-40%

Шеллийн бутнуур < 25%  
 Алаг өвс < 25%

Шеллийн бутнуур >35%  
 Алаг өвс >35%

Шеллийн бутнуур <25%  
 Алаг өвс < 35%

## 22.СӨӨГ БҮХИЙ ХУУРАЙСУУ-ЧИЙГСЭГ АЛАГ ӨВС-ТОМ ДЭГНҮҮЛТ ҮЕТЭНТ ӨНДӨР УУЛЫН НУГЫН БЭЛЧЭЭР

### 1. Соргог төлөв байдал



1.1 Сөөг бүхий хуурайсуу-чийгсэг алаг өвс – том дэгнүүлт үетэнт бүлгэмдэл



Шеллийн бутнуур




Хар үрт чаргай



Азийн төлөгч өвс

I




### 2. Үетэн багассан төлөв байдал



2.1 Сөөг бүхий том дэгнүүлт үетэн-хуурайсуу алаг өвст бүлгэмдэл


III

22.СӨӨГ БҮХИЙ ХУУРАЙСУУ-ЧИЙГСЭГ АЛАГ ӨВС-ТОМ ДЭГНҮҮЛТ ҮЕТЭНТ  
ӨНДӨР УУЛЫН НУГЫН БЭЛЧЭЭРИЙН ТАРХАЦЫН ЗУРАГ



Таних тэмдэг

- Тархац
- Аймгийн төв
- Аймгийн хил
- Нуур
- Сумын хил



Projection: WGS 1984  
UTM Zone 48N

## БЭЛЧЭЭР АШИГЛАЛТЫГ СЭРГЭХ ЧАДАВХИД ТОХИРУУЛАХ ЗӨВЛӨМЖ

Бэлчээр ашиглалтын эрчим, тэжээлийн нөөцийн бүрдэлт, тэжээл зарцуулалт, мал аж ахуйн бүтээмжийн тогтвортой байдал, түүнчлэн хөрсийг элэгдэл эвдрэлээс хамгаалах, усны ай савын экосистемийн тогтвортой байдлыг хангахад бэлчээрийн сэргэх чадавхид суурилсан ашиглалтын үндсэн зарчим болох боломжит даацыг баримтлах нь чухал.

### **Сэргэх чадавхийн**

**1-р түвшин:** Тухайн үеийн соргог төлөв байдлыг хадгалах зорилгот нийцүүлэн мал бэлчээрлэлтийн ачааллыг тухайн бэлчээрийн боломжит даацын хэмжээнээс хэтрүүлэлгүйгээр тохируулах шаардлагатай.

### **Сэргэх чадавхийн**

**2-р түвшин:** Төлөв байдлын тухайн үеийн түвшинг соргог түвшинд хүргэх үндсэн зорилгын хүрээнд ашиглалтын хэм хэмжээ, ачааллыг тухайн бэлчээрийн сэргэх чадавхид суурилсан боломжит даацаас 5 хувь доогуур байхаар тохируулан хөтөлнө. Ашиглалтын энэхүү хэмжээг соргог төлөв байдалд оруулах зорилготой хүрсний дараа өөрчлөх, нэмэгдүүлж тооцох боломжтой. Улирлын бэлчээрийн богино хугацааны сэлгээг нэвтрүүлэх, ашиглалтын хугацааг өөрчлөх замаар бэлчээрийн сэргэлт, сайжралтыг түргэсгэх боломжтой.

### **Сэргэх чадавхийн**

**3-р түвшин:** Төлөв байдлын доройтож өөрчлөгдсөн түвшинг соргог түвшинд хүргэх үндсэн зорилгын хүрээнд ашиглалтын хэм хэмжээ, ачааллыг тухайн бэлчээрийн боломжит даацаас 10 хувь доогуур байхаар тохируулан хөтөлнө. Тухайн бэлчээрийг улирлын туршид ашиглаж буй одоогийн горимд богино хугацааны сэлгээг оруулах нь илүү үр дүнтэй байх болно. Улирлын бэлчээр бүрээр ашиглалтын зохистой хугацаа болон байршлыг жил бүрийн төлөвлөлтөөр тогтоох бөгөөд энэ нь БАХ бүрийн бэлчээрийн онцлогт тохирсон, ялгаатай байх шаардлагатай. Жишээ нь, өвөлжөө/ хаваржааны бэлчээрийн зүүн хэсгийг нь эхний жилийн 1-р хагаст ашиглах, дараа нь үлдсэн хугацаанд баруун хэсэгт шилжиж ашиглах, дараа жил нь энэхүү 2 талбайг сэлгээний загварыг сөөлжүүлэх, өөрөөр хэлбэл, хугацааны эхний хагаст бэлчээрийн баруун хэсгийг, үлдсэн хугацаанд нь зүүн талыг ашиглах байдлаар зохицуулна гэсэн үг. Бэлчээр ашиглалтын горимын энэхүү тохируулгыг хамгийн багаар 7 жил, бэлчээр сэргэж соргог төлөв байдалд шилжих хүртэл өөрчлөлгүйгээр мөрдөх бөгөөд соргог төлөв байдалд шилжиж сайжирсан нөхцөлд ачааллыг өөрчилж нэмэгдүүлэх боломжтой.

### **Сэргэх чадавхийн**

**4-р түвшин:** Хүчтэй доройтсон бэлчээрийг сайжруулах, бүтээмж, чанарыг нэмэгдүүлэх зорилгыг хэрэгжүүлэх гол арга зам бол ашиглалтын ачааллыг бууруулахын зэрэгцээ ургалтын хугацаанд малын хөлөөс чөлөөлөх ажлыг хослуулах явдал мөн. Бэлчээрийн ачааллыг сэргэх чадавхид суурилсан боломжит даацаас 15 хувь доогуур байхаар тохируулахын зэрэгцээ 3 жил дараалан ургалтын хугацааны ашиглалтаас бүрэн чөлөөлөх шаардлагатай. Өөрөөр хэлбэл, хавар ногоо цухуйхаас хагартал малын хөлөөс бүрэн чөлөөлөх, ургамал тайван байдалд байх үед боломжит дооцоос 15 хувь хорогдуулсан ачаалаар ашиглах боломжтой. Эхний 3 жил дараалан ургалтын хугацаанд ашиглалтаас бүрэн чөлөөлсний дараа хоёр жил дараалан ургалтын хугацаанд нь боломжит даацаас 15 хувь доогуур ачаалалтайгаар ашиглах, дахин 3 жил ашиглалтаас чөлөөлөх, 2 жил дараалан ургалтын хугацаанд нь ашиглах загварыг нэвтрүүлнэ. Ийм зохицуулалт бүхий менежментийг дор хаяж 10 жил хэрэгжүүлж, соргог буюу зорилтот төлөв байдалд шилжиж сайжиртал үргэлжлүүлэх, харин бэлчээр сэргэж уг төлөв байдалд хүрсний дараа сэргэх чадавхид суурилсан даацад харгалзуулсан ачаалалтай ашиглана.

### **Сэргэх чадавхийн**

**5-р түвшин:** Төлөв байдлын энэ түвшинд хөрсний элэгдэл, эвдрэлийг сааруулах, хөрсний болон ургамлан нөмрөгийн тогтворжилтыг дэмжихэд чиглэгдсэн үндсэн зорилтыг бэлчээрийг урт, богино хугацаагаар ашиглалтаас чөлөөлөх, ачааллыг сэргэх чадавхид суурилсан даацаас 15 хувь доогуур түвшинд тохируулах зэрэг арга хэмжээг хослуулах замаар хэрэгжүүлэх боломжтой. Эхний хоёр жилийн хугацаанд бэлчээрээ ашиглалтаас бүрмөсөн чөлөөлнө. Ашиглалтаас чөлөөлсөн хоёрдахь жилээс залгуулаад ургалтын хугацаанд малын хөлөөс 3 жил дараалан чөлөөлнө. Сэргэх чадавхид суурилсан даацаас 15 хувь доогуур ачаалалтайгаар тайван буюу ургалтын бус хугацаанд ийм бэлчээрийг ашиглаж болно. Эхний 3 жил ургалтын хугацаанд ашиглалтаас чөлөөлсний дараагийн хоёр жил ургалтын хугацаанд нь боломжит даацаас 15 хувь доогуур ачаалалтайгаар ашиглах, дахин 3 жил ашиглалтаас чөлөөлөх, 2 жил дараалан ургалтын хугацаанд нь ашиглана. Зохистой ашиглалтын урт хугацааны энэхүү загварыг дор хаяж ургалтын улиралд ашиглалтаас чөлөөлөх 3 орчилтойгоор үргэлжлүүлэх хэрэгтэй.